

DPUB2
Монгол Улс
дахь ХБИ-ийн
хөдөлмөр
эрхлэлтийг
дэмжих
тогтолцоог
бэхжүүлэх
төсөл

DPUB2 МЭДЭЭ

№ 09
2022 оны Есдүгээр сар

1. Zangia.mn-ий оффисд зочиллоо

DPUB2 төслийн Япон мэргэжилтэн болон монгол ажилтнууд ажлын байрны зар, мэдээлэл түгээдэг Zangia.mn-ий оффист 8-р сарын 29-ны өдөр зочилж тус байгууллагын үйл ажиллагаа хариуцсан захирал Г. Төртөгтохтой уулзлаа.

Zangia.mn нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан ажлын байрны зарын булантай цорын ганц вэб хуудас. Тус компани хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, хувь хүний хөгжил зэрэг хөдөлмөрийн харилцаатай холбоотой цогц үйлчилгээ үзүүлэгч үндэсний компани юм. Г. Төртөгтох захиралын хэлсэнээр сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авах ажил олгогчдын тоо нэмэгдэж байгаа бөгөөд өдөрт 10 гаруй зар нийтлэгддэг ажээ.

DPUB2 төслийн зүгээс ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд ААНБ-уудын ойлголт хандлагыг нэмэгдүүлэх сургалтын талаар танилцуулав. Түүнчлэн Zangia.mn вэб сайтын шүүлтүүр/хайлтын талаарх техникийн зөвлөгөө, гишүүн байгууллагуудтай хамтран ажиллах, боломжуудын талаар санал солилцлоо.



DPUB2 төслийн мэргэжилтэн Исобэ Ёоко, монгол ажилтанууд Zangia.mn-ий оффисд

2. ААНБ-уудад нөлөөлөх сургалтын баг туршилтын семинараа хийлээ



Оролцогчид харааны бэрхшээлийн талаар ойлгох дасгал ажлыг хийж байна.

Нөлөөллийн баг ирэх 10-р сард зохион байгуулагдах ААНБ-уудад зориулсан давтлага сургалтаа хийлээ. 9-р сарын 8-ны өдөр давтлага сургалтаар оролцогч Г. Болормаа “ААНБ-уудад ХБИ-ийн үзүүлэх үнэ цэнэ”, Х. Батчимэг “ААНБ-ууд дахь тохирох хэрэглэгдэхүүний жишээ” гэсэн сэдвээр илтгэл тавив.

Бие эрхтний бэрхшээлийн талаар ойлголт өгөх практик дасгал ажлын чиглүүлэгчээр Ш. Оюунбат, Ц. Лхамжав, DPUB2 төслийн ажилтан Х. Энхжин нар тус тус ажиллаа.

Дээрх практик дасгал ажлын дараа DPUB2 төслийн ажилтан Х. Мөнхтуул “Ажлын байран дахь тохирох хэрэглэгдэхүүн” гэсэн сэдвээр туршилтын илтгэлээ танилцууллаа. ААНБ-уудын ойлголтыг нэмэгдүүлэх сургалт болоход нэг сар үлджээ. Тиймээс DPUB2 төслийнхөн сургагч багш нарын лекц тавих ур чадварыг дээшлүүлэхэд анхааран ажиллана.



Оролцогчид харааны бэрхшээлийн талаар ойлгох дасгал ажлыг хийж байна.



Оролцогчид хөдөлгөөний бэрхшээлийн талаар ойлгох дасгал ажлыг хийж байна.

СЭДЭВ

1 Zangia.mn-ий оффисд зочиллоо

2 ААНБ-уудад нөлөөлөх сургалтын баг туршилтын семинараа хийлээ

3 Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинарыг зохион 4 дэх удаагаа зохион байгууллаа

4 ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх давтлага сургалт зохион байгуулагдлаа

3. Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар зохион байгууллаа

DPUB2 төсөл 9 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар”-ыг 4 дэх удаагаа зохион байгууллаа. Тус семинарт хувийн хэвшил болон ТББ-ын нийт 31 хүн оролцлоо.

Семинарын эхний өдөр оролцогчид Ажлын байрны дадлагажуулагчийн үүрэг, хариуцлага болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн үйл ажиллагааны талаар суралцсан юм. Семинарын хоёр дахь өдөр, оролцогчид Ажлын байрны дадлагажуулагчийн дүрд орж “ААНБ-уудтай уулзалт хийх”, “Ойлгомжтой заах арга барил” гэсэн сэдвээр практик дасгал ажил хийв.

Өмнөх төгсөлтийн 6 төгсөгч энэ удаагийн семинарт ажлын байрны дадлагажуулагчийн талаар лекц тавьж Япон мэргэжилтнүүд ажиглагчаар оролцлоо. Тэд ажлын байрны дадлагажуулагчийн загвар төслийг хэрэгжүүлж байгаа туршлагаа энэ удаагийн семинарт оролцогчдод танилцуулсан нь оролцогчдын сонирхлыг ихэд татаж байсан юм.



4 дэх төгсөлтийн дурсгалын зураг

4. ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх давтлага сургалт зохион байгуулагдлаа

DPUB2 төсөл ирэх 10-р сард зохион байгуулагдах ААНБ-уудад ойлголт өгөх, нөлөөллийн семинарт бэлтгэх багийн давтлага сургалтыг зохион байгуулж байгаа билээ. Ээлжит давтлага сургалт 9-р сарын 19, 21-ний өдрүүдэд Монгол-Японы хүний нөөцийг бэлтгэх төвд зохион байгуулагдлаа. Уг сургалтаар DPUB2 төслийн зүгээс ААНБ-уудад зориулсан сургалтын материалд оруулах нэмэлт агуулга мөн тэдгээр агуулга яагаад чухал болох талаар нөлөөллийн багийн гишүүдэд сургалт явууллаа. Давтлага сургалтын хоёр дахь өдөр Оюутолгой, М-март, Мишээл группийн хүний нөөцийн менежерүүдийг урьж нөлөөллийн баг болон ААНБ-уудын хооронд панел хэлэлцүүлэг зохион байгуулсан юм.



Төслийн ахлах зөвлөх Чича Хисао ААНБ-уудад нөлөөлөх нөлөөллийн багт сургалтын материалын



DPUB2 төслийн урилгаар панел хэлэлцүүлэгт оролцсон ААНБ-уудын захиргаа, хүний нөөцийн дарга нар

Панел хэлэлцүүлгээр нөлөөллийн багийн гишүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ААНБ-уудад тулгарч байгаа бэрхшээл, шийдлийн талаар асуулт асууж санал бодлоо нээлттэй ярилцлаа. Уригдан ирсэн хүний нөөцийн менежерүүд тус хэлэлцүүлэгт оролцож хоорондоо мэдээлэл солилцон, бие биенээсээ суралцах сайхан боломж бий болгосонд талархаж цаашид DPUB2 төслөөс зохион байгуулах үйл ажиллагаанд оролцохоо илэрхийлж байлаа. Энэхүү давтлага сургалтаас ААНБ-уудад нөлөөлөх нөлөөллийн багийн гишүүд Монголын ААНБ-уудад тулгардаг гол асуудлуудыг олж мэдсэн гэдэгт итгэж байна.



dpub.jica@gmail.com



The Ministry of Labor and Social Protection, 4th khoroo, Chingeltei district, United Nation's street-5, Ulaanbaatar 15160, Mongolia



<https://www.facebook.com/jicadpub1and2>



<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

